ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 31 өдөр Дугаар А/100 Арвайхээр сум

С.Наранчимэгийн газар эзэмших эрхийг
Б.Намжилсүрэнд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмшигчийн гаргасан хүсэлтийн дагуу тус сумын Их-Уул Ягаантолгой 6 дугаар багийн 21 дүгээр гудамжны 5 тоот хаягт байрлах Сүхбаатарын Наранчимэгийн эзэмшлийн 6216033499 нэгж талбарын дугаартай, 36 жилийн эрхийн гэрчилгээний хугацаатай, 683 м2 хэмжээ бүхий гэр, орон сууцны хашааны газрын зориулалттай газар эзэмших эрхийг Бямбын Намжилсүрэнд шилжүүлсүгэй.

2.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны “Н.Балдандоржийн газар эзэмшлийн эрхийг С.Наранчимэгт шилжүүлэх тухай” А/182 дугаар захирамжийн С.Наранчимэгтэй холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3.Дээрх газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсэн орлогын хэмжээг дуудлага худалдааны анхны үнээс багагүй байхаар тооцсон татварын баримт болон газрын эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг Газрын даамал (Ш.Адъяадолгор)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:\2024\Alban bichig\Zahiramj- 2024.docx